



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/144

Мандалговь

Үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлж,
нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга С.Ууганбаяр нь гадаад улсад томилолтоор ажиллах болсон мөн үнэлгээний хорооны гишүүн Т.Эрдэнэбаяр нь шилжин явсан тул Орон нутгийн хөрөнгөөр санхүүжих "Цагаандэлгэр сумын Сургуулийн албан хэрэгцээнд автомашин" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

Хоёр. Орон нутгийн хөрөнгөөр санхүүжих "Цагаандэлгэр сумын Сургуулийн албан хэрэгцээнд автомашин" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар Г.Жавзмаа, гишүүнээр Б.Батхүү нарыг нөхөн томилсугай.

Гурав.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Түвшинбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190383